



ХИЛ СУДЛАЛ, ОЮУЛ, ПРАКТИК

Хил түүний үүсэл

Ертөнц бол өөр өөрийн онцлогтой олон төрөл зүйлийн нэгдэл бөгөөд түүний учир зүйг нь зөвхөн хүн л олох гэж оролдож, давуу талаараа ертөнцийн зарим нэг зүй тогтол, хуулийг нь хүн эрх ашигтаа зохицуулан байгааг буурал түүх, цаг хугацаа харуулж байгаа билээ.

Хүн төрөлхтөн уураг тархины сэтгэн бодох чадвар, ухамсар, оюун хөгжлөөрөө бусад амьтдаас хол тасарч, нийгмийн харилцааг үүсгэн, их бага газар нутаг эзэмдсэн улс гүрэн бий болгосноор тухайн улс орны бүрхүүл арьс буюу нэг үгээр улсын хил гэсэн ухагдахуун гарч ирсэн. Улсын хил нь газар оронтой холбоотой объектив, нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан субъектив шинж чанаруудтай юм. Хил гэдгийг Монгол хэлний товч тайлбар тольд (1996 он): “Хил гэдэг нь нутаг, газар орны хоорондын зааг” гэж тайлбарлажээ.

Харин орос хэлний тольд: □Хил гэдэг нь хөрш зэргэлдээ мужуудын эзэмшил газар нутгийн зах хязгаар зааг болон хуваан тусгаарлаж байгаа тэр зурвас юм. Зэргэлдээ улсуудын усан буюу хуурай газар нутгийн заагийг тодорхойлох зурвас, хязгаар юм” гэсэн байх агаад цэргийн нэвтэрхий тольд “Улсын хил гэдэг нь хөрш улс орон, задгай тэнгисээс улс орны нутаг дэвсгэрийн зах хязгаарыг илэрхийлэн зайчладаг босоо хавтгай дайран өнгөрдөг шугам юм” гэжээ. Оксфордын тайлбар тольд “хил гэдэг нь хоёр улсыг хувааж буй шугам бөгөөд түүний орчмын газар нутгийг хэлнэ” гэжээ.

Хил гэдэг үгийг зөвхөн газар нутгийн заагийг илэрхийлсэн утгаар нь тайлбарласан байна.

ХИЛ СУДЛАЛ

Хүн төрж өссөн газраа ураг төрлөөрөө омог байна. Улс гүрний хил нь нийгмийн байгууллаас үүдэлтэй учраас түүнтэй салшгүй холбоотой бөгөөд Монголын нийгмийн байгуулал Хүннүгийн үеэс өөрөөр хэлбэл хүй нэгдлийн нийгмийн байгуулал задарсан тэр цагаас феодалын нийгмийн байгуулалд боолын нийгмийн байгууллыг алгасан орсон байдаг бол хүннү нар нь төв азийн нүүдэлчдийн түүхэнд анх МЭӨ 209 онд төр байгуулсан юм.

Монголчууд хүннүгийн үеэс одоог хүртэл нэг газраа тогтож хот суурин байгуулж байсангүй, тогтсон тодорхой хэсэг нутагт бэлчээрийн мал аж ахуй эрхлэн дөвөн цагийн эргэлтэд нүүдэллэн амьдардаг байсан бөгөөд малын бэлчээр газар нутгийнхаа зах хязгаарыг хатуу тогтоосон овгоороо тэмдэглэдэг байжээ.

Хүннү нарын хаан Түмэн шаньюйг хүү Модун алж МЭӨ 209 онд засгийн эрхийг авч шинэтгэл хийн хүннү нарын сурвалжтаны үе улирах эрх мэдлийг бэхжүүлж, мэдлийнхээ газар нутгийг гурав хуваан тус тусынхаа нутаг дэвсгэрийн зах хязгаар заагийг хатуу тогтоож өгсөн байна.

Энэ үед улс бүр өөрийн газар нутгийг зах хязгаар, заагтай байх гэсэг оролдлого хийж байсан нь олон зүйлээр нотлогддог. Турхайлбал МЭӨ 192 онд Хан улсын эзэн хаан Сяо Вынь – ди, Хүннүгийн Модун хаан (шаньюйн) –ы хүү Лаошанд явуулсан бичигтээ:

“Урт хотоос хойш, нум барьсан улс Чан – юйн (шан-гайн) цаазыг дагасугай. Урт хотоос дотогш дээл, малгайн улсыг би захирсугай..” гэсэн нь (хятадууд) нанхиадууд нүүдэлчдийн байнгын довтолгооноос айж эмээхдээ босгосон 4000 гаруй км алдарт цагаан хэрмээр нутгийнхаа зах хязгаарын зааг, хил тогтоох оролдлого хийж байсныг гэрчилж байна.

Ер нь монгол гзар нутаг дээр байсан Хүннү (МЭӨ II), Сяньби (МЭӨ II), Жужан (МЭ V), Түрэг (МЭ VI), Уйгур (МЭ VIII), Кидан (МЭ X), Монголын их эзэнт гүрэн (МЭ XII), Монголын Юан улс (МЭ XIII) зэрэг нь хөрш улс орнуудтай газар нутгийн заагаа зах хязгаарын бүхэл бүтэн хошуу, аймгийн нутгийн хэмжээнд маш тодорхой тогтоож цэрэгжсэн айл өрх болон аравт, зуутаараа халдан

довтлогсодтой тэмцэлдэхийн зэрэгцээ бусдын нутаг дэвсгэрийг эзлэн авч, газар нутгаа тэлэх, нэгэнт өөрийн болсон хэсгээ хамгаалах арга хэмжээг авч байсан байдаг.

Монголын эзэнт гүрний хүч суларч дотоодын зардал газар авсан тэр үед хятад газар Манж гүрэн ноёрхолоо тогтоохын зэрэгцээ Монголыг эзлэн авах тууштай бодлого явуулж газар нутгийг нь мэдэлдээ авсан даруйдаа Монголын умард хилийн талаар санаа зовсон нь Их Эзэн Чингисийн монголчуудын газар нутгийг нь эзлэн авч, сүр хүчийг нь дарж чадлаа хэмээн дэлхий дахинд харуулах, Ар Монголыг өөрийн мэдлээс алдахгүй гэсэн хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөн Монгол Оросын хилийг яаран тогтоож тодотгохыг хүссэн явдал юм.

Ингэж түүхэнд анх удаа газар орон дээр тэмдэглэгдсэн олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн хил үүсэн бий болсон байна.

Олон улсын хэмжээний цаг хугацаа шаардсан чимхлүүр ажиллагаа болох улсын хилийг хил залгаа улстай тодорхойлж тогтоон, газар дээр тэмдэглээд зурагт оруулан протокол үйлдэж хилийн гэрээ байгуулан баталгаажуулж смахин хамгаалах нь нарийн цогц арга хэмжээ бөгөөд төрийн бодлогын хэмжээнд өргөн хүрээг хамран зохицуулах маш чухал асуудал байдаг.

Монгол улсын хил нь XVIII зууны дунд үе хүртэлх хугацаанд бүрэлдэн тогтсон гэж түүхийн ухааны дэд доктор Б.Цэдэн □ Иш бичсэн байгаа.

Монголын хилийн талаар XVIII зуунаас өмнөх үеийн түүхийн баримт бичгүүдэд маш ховор дурьдагдсан байдаг бөгөөд зөвхөн нутгийн хойд, зүүн, баруун хязгаар нь мэдэгдэж байсан болохоос газар нутаг дээр улсын хил гэгч зүйл байгаагүй байна.

Оросын хаант засаг, Манж гүрэн хоёрын 1727 оны Буурын голын хилийн гэрээ, 1864 оны Тарвагатайн хилийн гэрээнээс хойш Автономит Монгол улсыг хүрэтл Оростой ч, Манж хятадтай ч монгол улсын хилийн талаар дахин яригдаагүй байна.

ХИЛ СУДЛАЛ

Энэ хугацаанд зөвхөн орон нутгийн чанартай малын бэлчээрийн зах хязгаар заагийн талаар олон дахин яригдан маргаантай асуудлыг Манжийн түшмэдийн оролцоотойгоор орон нутгийн засаг ноёд шийдвэлэж байсан байдаг.

Эрт дээр цагаас аливаа үндэстэн улс газар нутагтаа аянчин, жинчдийг тодорхой тогтоосон гарцаар нэвтрүүлж тогтоогдоогүй газраар нэвтрэх тохиолдолд бүхнийг газар нутагт халдаснаар үзэж цэрэг зэвсэг хөдөлгөж байсан нь тэд өөрийн арьс болох бусад үндэстэн улсын нутаг дэвсгэрээс өөрийн үндэстэн улсын нутаг дэвсгэрийг заагладаг хилтэй байжээ гэж үзэж болно. Ингэж бий болсон улсын хил нь зөвхөн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал биш, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын бат цайз болох учраас аль ч улсын төрийн бодлогын нэг чухал асуудал болдог байна.

Улсын хил нь нэгэнт хоёр улсын нутаг дэвсгэрийн зааг болохоор тус тусын нутаг дэвсгэр дээрхи амьдрал, үйл ажиллагаа, эд баялаг болон байгаль дэлхийн гэхээс бусад бүх зүйлийг зааглан байх ёстой болно. Ингэж улсын хил улс хоорондын газар нутгийг зааглахаас гадна улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг тусгаарлан өгдөг ба нэгэнт хоёр улс тохиролцон гэрээ байгуулсан бол тус тусын хариуцсан үүргийн дагуу гэрээнийхээ заалтуудыг биелүүлэх болдог хатуу журамтай юм.

Улсын хилийн талаархи шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголт хүн бүрд ижил байдаггүй. Улсын хилийг шугамын төдийхнөөр төсөөлж байдгаас түүнтэй хамааралтай олон асуудал орхигдон шинжлэх ухаан, техник мэдээлэл өндөр хөгжсөн өнөө үед түүний байх эсэх тухай маргаан ихээр гарч ирээд байна.

Үндэстэн улсууд нэгдэх, задрах үйл явц идэвхитэй явагдаж байгаа энэ үед улсын хилийн асуудлаархи төрийн бодлого алдагдвал үндэсний аюулгүй байдалд аюул тохиолдож, дайн самуун гарах, улс оронд хүн болон нийгэм, эдийн засгийн асар их хор хохирол учирч мөхөлд ч хүрч болохыг энэ зууны төгсгөл, шинэ зууны эхний үеийн дэлхийн улс орнуудын байдал харуулж байна. Ямарваа улс орны амьдрал өөрийн арьс улсын хил дотор байж гаднахи орчинтой нь зөвхөн тэр холбож байдаг. Үүгээрээ улсын хилийн асуудал өргөн хүрээг хамарсан зарим тохиолдолд зангилаа ч болох талтай.

Төр, үндэстэн (ард түмэн) түүний ген буюу биологийн тогтоц байх тэр цагт хил гарцаагүй байх болно. Яагаад гэвэл үндэстэн (ард түмэн) хэмээгч субъект өөрийн ген биологийн тогтоц, орон зай, цаг хугацааг эзлэн байдгаас гадна нийгмийн харилцаа үүсгэгч хүчин бөгөөд манай дэлхийн улс гүрэн, төр ард түмэн нь хоорондоо эдийн засаг, нийгэм улс төр шинжлэх ухааны хөгжлийн түвшингээрээ асар их ялгаатай учир тив, дэлхийгээрээ нэгэн төр, улс болох нь ихээхэн цаг хугацаа эзэлсэн боломжгүй шахуу асуудал юм.

Даяарчлал эдийн засаг, худалдааны салбарт эхлээд газар авч байгаа бөгөөд яваандаа нийгэм, эдийн засаг, улс төр болон байж болох бүх салбарт явагдах үзэгдэл болж хувираад байна.

Үүнтэй уялдан улсын хилийн асуудал мөн яригдаж байгаа ба зарим судлаачид түүнийг устаж үгүй болох хамгийн эхний зүйл гэж үздэг.


Хүн төрөлхтөний хөгжлийн түвшин дээшлэх тутам улсын хилийн асуудал субьектив шинж чанартай болж бэлгэдлийн гэрч бүү хэл устаж үгүй болно хэмээн үздэг явдал дэлхийчлэгдэх асуудлаас үүдэн гарч ирлээ.

Гэтэл хүн төрөлхтөний доторхи үндэс угсаа, нийгмийн байгуулал, хөгжил, шашин шүтлэг, зан заншил, соёл урлаг, арьсний өнгө, биологийн тогтоц, дүр төрх гэхчилэн олон асуудал хил хязгааргүй болон нэгдэж чадах болов уу гэдэг асуудалд хэн ч хариулт өгч чадахгүй байна.

Саяхан олон улсын хил судлалын төвөөс зохион байгуулсан бага хурал дээр профессор Херберт Диттген □Санхүү, зах зээл, үндэстэн дамнасан хамтын ажиллагаанд нэг үндэстэн улс хяналт тавьж чадахаа нэгэнт больж үйл ажиллагаа нь ч алдагдаж даяарчлалын хоморгонд автагдахад газар нутгийн хил мөн өөрийнхөө утгыг алдаж болох талтай. Миний өгүлэх гэж буй сэдэв бол хилийн үйл ажиллагааны тухай боловч хилийн үүрэг, зориулалтын өөрчлөлтийг гол нь хөндөх юм.

Үндэстэн улсын хил нь нийгэм, улс төрийн үүргээрээ таван янз байна гэж үздэг.

ХИЛ СУДЛАЛ



Энэ нь:

1. Уламжлалт цэргийн үүрэг, өөрөөр хэлбэл хамгаалах үүрэг
2. Хуулийн өмнө хүлээх үүрэг
3. Үзэл суртлын талаар үүрэг хүлээх
4. Эдийн засгийн чиглэлээр хүлээх үүрэг
5. Нийгмийн сэтгэлгээ сэтгэл зүйн хувьд хүлээх үүргийг тус

тус багтаажээ.

Энэ бүгд даяарчлалын нөхцөл байдалд улсын хилийн улс төр, үзэл суртлын ач холбогдол хичнээн чухал болохыг харуулж байдаг. “Үндэстэн улсын үүрэг нь зөвхөн зохицуулалтын шинж чанартай болно. Төр засаг, улс төрийн халдашгүй дархан байдлын баталгаа болж үндэстэн улс оршин тогтнох” юм гэжээ.

*Хилийн албаны тэнхимийн дарга
докторант, хурандаа Б.Бат – Эрдэнэ*